

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС АГЕНТЛАГ, СУМДЫН
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.01.02

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

2017 оны 12 дугаар сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VIII хуралдаан болж, аймгийн 2018 оны төсвийн төслийг хэлэлцэж баталлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2 удаа хуралдаж, 19 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Уг хуралдаануудаар аймгийн 7 хөтөлбөр, 2 дэд хөтөлбөр болон бусад асуудлыг хэлэлцэн баталлаа.

Сайхан суманд Буддын шашны “Тод Монгол үсгийн хийд”, Түшиг суманд Христийн шашны “Түшиг чуулган” сүм байгуулах байгуулах зөвшөөрлийн тус бүр 3 жилийн хугацаагаар байгуулах зөвшөөрлийг олгосон.

2018 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай мод, түлээ бэлтгэх хуваарийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй болсон зарим байгууллагын үндсэн хөрөнгийг актлах болон шилжүүлэх шийдвэрийг хэлэлцэн баталсан.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагаа хөтөлбөрт туссан аймгийн хөтөлбөрүүдийн төслийг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг эхлүүлээ. Үүнд:

1. “Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” аймгийн хөтөлбөр
2. “Гадаад харилцааг эдийн засагжуулах” аймгийн хөтөлбөр
3. “Сэлэнгийн бренд” аймгийн хөтөлбөр
4. “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” аймгийн хөтөлбөр
5. “Соёл урлаг-Хүний хөгжилд” аймгийн хөтөлбөр
6. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл орчныг сайжруулах” аймгийн хөтөлбөр
7. “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” аймгийн хөтөлбөр

Засаг захиргааны анхан шатны нэгж болох багаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, багийн Засаг даргын үйл ажиллагааг идэвхжүүлэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймаг орон нутгийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах асуудлуудыг тодотгох зорилгоор “**Төрийн үйлчилгээ-багийн Засаг дарга**” сэдэвт сургалтыг 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Манлайлал, удирдлага хөгжлийн академитай хамтран зохион байгуулж, нийт сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга, холбогдох байгууллагуудын дарга нарыг хамрууллаа.

“Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, “Ажлын хариуцлага, ажлын цаг

ашиглалтыг сайжруулж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 2016 оны 05 тоот албан даалгавруудын хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмж, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны манлайлал, мэргэшил, харилцааны түвшинг сайжруулах санал зөвлөмж гарган бүх шатны төрийн байгууллагуудад хэрэгжүүлэх зорилгоор “**Төрийн алба-сахилга хариуцлага**” сэдэвт зөвлөгөөнийг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Манлайлал, удирдлага хөгжлийн академитай хамтран нийт сумдын удирдлагууд болон аймгийн төвийн төрийн албан хаагчид 400 гаруй хүнийг хамруулан зохион байгууллаа.

Олон улсын Хүний эрхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай аймгийн Засаг даргын 2017 оны А/492 дугаар захирамжийн хүрээнд 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдэд ойртуулах ажлын хүрээнд Ерөө бүсийн төвд ТҮЦ машин байршуулах талаар судалгаа тооцоог гаргаж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлснээр Ерөө сумын Засаг даргын Тамгын газарт ТҮЦ машиныг байршуулж, ашиглалтанд орууллаа. Ингэснээр аймгийн хэмжээнд Сүхбаатар, Мандал, Сайхан, Ерөө сумдад ТҮЦ машинаар иргэдэд төрийн үйлчилгээг хүргэдэг боллоо.

“Суралцагч байгууллага-төрийн албаны манлайлал” хөтөлбөр, “Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, аймгаас төрсөн алдар суутнууд, түүхийн дурсгалт, аялал жуулчлалын болон байгалийн үзэсгэлэнт газруудын мэдээлэл, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудаас явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Үзэсгэлэнт Сэлэнгэ-2018” цаг тооны бичгийг бэлтгэн хэвлүүлж, иргэд олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулж байна.

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, улс, аймгийн чанартай уралдаанд онцгой амжилт үзүүлсэн, эрхэлсэн ажлаа чанартай гүйцэтгэж байгаа амжилтыг урамшуулан БНХАУ-ын Бугат, Манжуур хотод боловсролын салбарын чиглэлээр туршлага судлах арга хэмжээнд 2 захирал, 5 мэргэжилтэн, 9 сургалтын менежер, 34 багшийг тус тус хамрууллаа.

ОХУ-ын Буриад Улсын Ардын Хурлын дарга Доржиев Цырен-Даши Эрдынеевичээр ахлуулсан бүрэлдэхүүн Сэлэнгэ аймагт айлчилж, аймгийн ИТХ-тай хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа. Сэлэнгэ аймаг, Буриад улсын олон жилийн найрамдалт найрсаг, дотно харилцааг бэхжүүлэх, цаашдын хамтын ажиллагааг тодотгон батжуулахад 2 тал харилцан идэвх санаачлагатай ажиллахаар харилцан тохиролцлоо.

ОХУ-ын Буриад улсын үйлдвэрчний эвлэлийн холбоо, ажил олгогч эздийн холбоо, төр хэрхэн хамтран ажилладаг талаар харилцан туршлага солилцох ажлаар Сэлэнгэ аймгийн хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт салбар хорооны бүрэлдэхүүн ОХУ-ын Буриад улсад ажиллалаа. Улаан Үүд хотод туршлага судлах ажлын үеэр аймагтаа үйлдвэрлэгддэг бүтээгдэхүүн, үйлдвэрлэгч эздийн үйл ажиллагааг сурталчлан танилцууллаа.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас аймгийн Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран “Сэлэнгэ аймгийн үсчин, гоо сайханч, хумс дизайны үр чадварын тэмцээн”-ийг

амжилттай зохион байгууллаа. Энэхүү уралдаан тэмцээн нь үсчин, гоо заслын салбарт ажиллагсдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажлын туршлага солилцох, харилцан суралцах цаашлаад салбарын харилцан ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн ажил арга хэмжээ болсон.

Онцгой байдлын талаар:

Онцгой байдлын газрын даргын баталсан “Шинэ жил” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүйн шаардлагыг тодорхойлсон стандарт, техникийн нормативын хэрэгжилтийг шалгаж, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдалд нь үнэлгээ, дүгнэлт өгч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан зэрэг сумдад үйл ажиллагаа явуулж байгаа улсын онц чухал болон галын аюултай объектуудыг хамруулан хяналт шалгалтыг хийсэн.

Сүхбаатар сумын “Олон Улсын худалдааны төв”, “Гурван мэргэд” хүнс барааны зах, “Сэлэнгийн Долгио” чуулга, улсын онц чухал объектууд Сайхан сумын Хөтөлийн “Цемент Шохой” ХК-ийн Дулааны станц, ерөнхий боловсролын сургууль, “Соёлын төв”, “Шим” худалдааны төв, “Баптист сүм”, “ЭКО” паб, буудал, “Чандмань”, “Баясгалан”, “Залуус”, “Nice” зоогийн газрууд “Шунхлай” ХХК-ийн шатахуун түгээх станцууд, “Тэс Петролиум” ХХК-ийн шатахуун түгээх станцууд, “МТ” ХХК-ийн шатахуун түгээх станцууд, “Сод Монгол” ХХК-ийн шатахуун түгээх станц, “Ник” ХХК-ийн шатахуун түгээх станц, агуулах, “Дашваанжил” ХХК-ийн АХЦС зэрэг нийт 89 аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт, шалгалтыг хийж 231 зөрчлийг илрүүлэн үзлэг шалгалтын явцад 51 зөрчлийг арилгуулан бусад зөрчлийг арилгуулахаар гал түймрийн болон гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 16, мэдэгдэл 73-ийг үйлдэж байгууллагын дарга, эрхлэгч нарт өгсөн.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг баар, ресторан болон худалдааны төв, зах, хүнс барааны дэлгүүрүүдийн гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдал нь хамгаалагдсан байдал, гэрлэн чимэглэл, пиротехникийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны талаар заавар, зөвлөмж, сэрэмжлүүлэг материал тараан өгч, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 355 сурагчдад пиротехникийн хэрэгслийн аюулгүй байдлыг хэрхэн хангах тухай сургалтыг зохион байгуулсан.

Шинэ жилийн баярын өдрүүдэд салют, пиротехникийн хэрэгслийг ард иргэд худалдан авч ашиглахгүй байх, заавар зөвлөмжийн дагуу галын аюулгүй байдлыг хангаж ашиглахыг анхааруулсан мэдээ мэдээлэл, ярилцлагыг Сүхбаатар, Сайхан сумдын Миний Монгол, Эрдэнэ КаТВ-үүдээр иргэдэд аюулгүй ажиллагааны талаар мэдээлэл өгч ажилласан.

Мандал сумын худалдааны гудамжинд байрлах Баялаг худалдааны төв, барааны захын хажуугийн Симба барааны дэлгүүр, ЗДТГ-ын хажуугийн Хас банкны барилгын хананд тус тус сэрэмжлүүлэг бүхий хулдаасан самбар өлгөж ард иргэдэд сэрэмжлүүлэг хүргэж ажиллаа.

Мэргэжлийн хяналтын чиглэлээр:

2017 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд хяналтын 20 чиглэлээр 554 төлөвлөгөөт хяналт шалгалт, 309 төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсанаас 554 объектод хяналт шалгалт хийж /үйл ажиллагаа зогссон 22/ гүйцэтгэл 100 хувь, зөвлөн туслах үйлчилгээнд 309 объект хамруулж /үйл ажиллагаа зогссон 17/ гүйцэтгэл 100 хувьтай биелэгдэж, хяналт шалгалт, зөвлөн туслах

үйлчилгээний төлөвлөгөөний биелэлт нийт 100 хувьтай хангагдлаа. Төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарлагдсан 22 хуулийн этгээд, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөгдсөн 17 хуулийн этгээд нь үйл ажиллагаа явуулаагүй, зогссон зэрэг шалтгаануудаар хяналт шалгалтад хамрагдаагүй болно.

МХЕГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу 454 хуулийн этгээдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, 173 хуулийн этгээдийг тандалт судалгаанд, 278 хуулийн этгээдийг хяналт шинжилгээнд хамруулж, төлөвлөгөөт бус 215 объектод хяналт шалгалт, иргэдийн өргөдөл, гомдол, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр 48 шалгалтыг тус тус хийж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Хяналт шалгалтын явцад 5251 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 2466 заалт бүхий 511 албан шаардлага хүргүүлж 136,847,000 мянган төгрөгийн торгууль, шийтгэвэр, 97,368,000 мянган төгрөгийн нөхөн төлбөр тус тус оногдуулж торгууль, шийтгэвэрийн барагдуулалт 97,4 хувьтай, нөхөн төлбөрийн барагдуулалт 88,4 хувийн биелэлттэй байна.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Үйлчилгээний баталгаажуулалт:

5 аж ахуйн нэгжийн үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 5 худалдаа, үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Сайхан сумын ерөнхий боловсролын 12 жилийн дунд сургууль, Сүхбаатар сумын 1, 2, 3-р 12 жилийн дунд сургуулиудын цайны газар, сургуулийн орчмын худалдаа үйлчилгээний 5 газарт “Хоолны газрын ангилал, зэрэглэл-Үндсэн шаардлага MNS 4946:2005”, “Худалдааны газар, түүний үйлчилгээ. Үндсэн шаардлага MNS 5021:2007” стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гарган, шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагууд болон сургуулийн захиргаанд зөвлөмж хүргүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг анхааруулсан.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт:

Сумын 2 аж ахуйн нэгжийн 2 нэрийн 5 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж өгсөн.

Стандартын салбар сан:

Стандартын салбар сангаас 3 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 5 нэрийн 6 стандартын борлуулалт хийж, үйлчилгээ үзүүлсэн. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгийн захиалгын дагуу 19 нэрийн 19 стандартаар хангаж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээ:

Эзлэхүүн хэмжлийн чиглэлээр Алтанбулаг сумын 32 айлын орон сууцанд суурилуулах 48 ширхэг халуун хүйтэн усны тоолуурыг шалган баталгаажуулсан.

Хөтөлийн “Цемент Шохой” ХК-ий үйлдвэрийн сорилт шинжилгээний лабораторид ашиглагддаг 16 лабораторийн жин, туухайг шалгалт тохируулгад хамруулж, 14 ширхэг жин шаардлага ханган хэмжилтүүд хийгдэн, “Шалгалт тохируулгын гэрчилгээ” олгож, 2 жинг ашиглахгүй байх тухай мэдэгдэл өгсөн. Шалгалт тохируулга хийсэн тухай техник ашиглалтын паспортод нь бичилт хийгдсэн.

Хөтөлийн “Цемент Шохой” ХК-ий үйлдвэрийн дамжлага дундын 10 жин, автомашины 1 жинг шалган баталгаажуулалтанд хамруулан гэрчилгээ олгов. Хуурай

цементийн үйлдвэрт ашиглагддаг 1 ширхэг электрон автопүү нь шалгалтын явцад тохиргоо хийх боломжгүй зөрүүтэй заалтууд зааж байсан тул баталгаажуулах боломжгүй, тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар засвар тохируулгын ажил гүйцэтгүүлсний дараа дахин шалгуулах нь зүйтэй гэж зөвлөсөн.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Улсын Их Хурлаас 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 8.5.2 болон 64.1.2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Сэлэнгэ аймгийн 2018 оны төсвийн төслийг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хэлэлцүүлэн аймгийн төсвийн нийт орлого, зарлагыг 71'069.9 мянган төгрөгөөр өргөн батлуулсан.

2017 оны төсвийн жил дуусгавар болж байгаатай холбогдуулан төсвийн байгууллагуудад санхүүгийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөх чиглэлийг хүргүүлж, Монгол Улсын Засгийн Газрын 52 дугаар хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу төрийн албан хаагчдад олгох урамшуулалыг олгох ажлыг орон нутагт зохион байгуулсан.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	18,762,417.4	20,510,662.4	109.3
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	12,024,962.9	11,774,014.6	97.9
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	72,416,331.4	65,549,678.2	90.5
	- Аймгийн төсвийн зарлагын дүн	17,127,116.5	15,296,812.6	89.3
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	660,799.2	591,478.0	89.5
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	941,578.5	704,129.3	74.8
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,687,453.9	1,525,387.3	90.4
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	2,008,547.8	2,008,547.8	100.0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	3,323,009.0	3,323,009.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	42,796,494.5	42,796,494.5	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	22,388,412.9	22,388,412.9	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	10,975,997.5	10,975,997.5	100.0
	- Соёлын байгууллага	2,803,873.6	2,803,873.6	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	1,027,714.4	1,027,714.4	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	5,118,977.6	5,118,977.6	100.0
	- ГХБХБГазар	206,884.8	206,884.8	100.0
	- ГБХЗХГазар	274,633.7	274,633.7	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	42,796,494.5	42,796,494.5	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	22,388,412.9	22,388,412.9	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	10,975,997.5	10,975,997.5	100.0
	- Соёлын байгууллага	2,803,873.6	2,803,873.6	100.0

	- Биеийн тамир спортын байгууллага	1,027,714.4	1,027,714.4	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	5,118,977.6	5,118,977.6	100.0
	- ГХБХБГазар	206,884.8	206,884.8	100.0
	- ГБХЗХГазар	274,633.7	274,633.7	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	3,330,030.6	3,342,042.2	100.4
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2,143,571.1	2,124,250.9	99.1
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	983,305.1	707,135.4	71.9
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	519,100.3	471,486.3	90.8
11	Тусгай сангуудын зарлага	1,514,175.2	439,569.4	29.0

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2017 XI - сар	2017 XII - сар	2017- XII 2017- XI /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 250	1 250	
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 100	
	Нарийн боов /кг/	2 500	2 500	
	Будаа /кг/	2 200	2 400	+200
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	5 000	5 000	
	Үхрийн мах /кг/	5 500	5 500	
	Адууны мах /кг/	6 500	5 500	-1 000
	Ямааны мах /кг/	5 000	5 000	
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	3 000	
	Хиам /чанасан, кг/	11 000	12 000	+1 000
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	800	1 000	+200
	Сүү / савласан, л/	2 600	2 600	
	Тараг /задгай, л/	1 200	1 200	
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	13 000	
	Айраг /л/	3 500	3 500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	
	Өндөг /ш/	300	320	+20
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 900	+100
	Өөхөн тос /кг/	1 800	1 800	
	Шар тос /кг/	11 000	11 000	
	Масло /задгай, кг/	4 500	5 000	+500
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 200	1 200	
	Лууван /кг/	1 500	1 500	
	Манжин /кг/	1 500	1 500	
	Байцаа /кг/	1 500	1 500	
	Сонгино /кг/	1 500	1 500	
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	4 500	4 500	

	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 800	2 800	
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 480	1 480	
	Бензин А - 92	1 630	1 630	
	Дизелийн түлш	1 720	1 720	

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, сургалт, сурталчилгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:

Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Шатар сонирхогчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулж, эрэгтэй төрөлд 32, эмэгтэй төрөлд 10 тамирчин өрсөлдсөнөөс эрэгтэй төрөлд: 1-р байранд Батсайханы Хишигтөр, 2-р байранд Хүрэлцоожийн Түмэнхүслэн, эмэгтэй төрөлд: 1-р байранд Сандагийн Эрдэнэчимэг нар тус тус шалгарч дараагийн шатны тэмцээн болох Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор боллоо.

-ХЭХҮХ-ийн хэрэгжилтийн сүүлийн 5 жилийн буюу 2012-2017 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэн гаргаж ХЗДХЯ-д хүргүүлсэн.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран “Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт” тулгамдсан асуудал сэдэвт онол практикийн бага хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын уулзалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн анхан болон давж заалдах шатны Шүүхүүд, Прокурорын газар болон Тагнуул, Цагдаа зэрэг хууль сахиулах байгууллагууд болон аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч нар оролцлоо. Уулзалт зөвлөгөөнд хууль сахиулах чиглэлээр 2017 онд авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн, 2018 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хамтран ажиллах бодлого чиглэлээ тодорхойлж, харилцан санал солилцлоо.

Архивын чиглэлээр:

12 дугаар сарын 03-наас 05-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Монгол Улсад орчин цагийн архивын салбар үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойн баярын хүрээнд зохиогдсон сагсан бөмбөгийн тэмцээнд Сэлэнгэ аймгийн эрэгтэй баг тамирчид дэд байр эзэлж, Мэргэжлийн хяналтын газрын архив, бичиг хэргийн ажилтан “Шилдэг тоглогч”-ийн шагналыг хүртсэн.

ОХУ-ын Буриад улсын Хиагтын районы архивын үйл ажиллагаатай танилцан, Сэлэнгэ аймагтай холбоотой баримт бичгийг судалж хуулбарлан авах талаар харилцан санал солилцож хамтран ажилласан. Уулзалт арга хэмжээгээр хоёр тал харилцаа холбоо тогтоон цаашид харилцан туршлага солилцох, хамтын ажиллагаагаа бэхжүүлэхээр болсон.

Төрийн архивын АМС программд Дулааны цахилгаан станц, Эмийн сангуудыг удирдах газрын хөмрөгийн 43 ХН-ийн 1970-2002 оны 3684 хуудасны агуулгыг уншуулж, заалт 3851, хүний нэр 20792, байгууллагын нэр 170, газар зүйн нэр 401-ийг шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

Ерөө бүсийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөн туслах чиглэлээр ажиллан 82 цагийн хичээл, үйл ажиллагааг ажиглаж, 108 багш, ажилтанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. "Өөрчлөлтийг чиглүүлэгч" төвөөс зохион байгуулсан сургалтад 11 сургуулийн 411 суралцагч, 308 багш хамрагдсан. 12-р ангийн 448 суралцагчдад "Мэргэжлээ зөв сонгож ирээдүйнхээ эзэн болохуй" 6 цуврал багц номыг, 325 багшид "Багшийн хөгжлийн тэмдэглэлийн дэвтэр" өгч номыг хэрхэн зөв хэрэглэх, дэвтрийг хэрхэн ашиглаж ажлаа зөв зохион байгуулах талаарх сургалт зохион байгуулсан.

Монгол Улсын боловсролын их сургуулийн Математик байгалийн ухааны сургуулийн Мэдээлэл зүйн тэнхимээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Мультимедиа програм хангамжийг сургалтанд хэрэглэх, хөгжүүлэх нь" үндэсний Х уралдааны сүүлийн шатанд нийт 13 шилдэг бүтээлүүд өрсөлдсөнөөс манай аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн англи хэлний багш Ч.Сайнбаяр 5-р ангийн "Sally is wearing blue jeans" цахим хэрэглэгдэхүүнт хичээлээрээ дэд байранд шалгарсан амжилт үзүүлсэн.

Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд "Ахмадын зөвлөх үйлчилгээний баг"-ийг ажиллуулж, боловсролын салбар дахь залуу, дунд, ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлэх, залуу багш, удирдах ажилтнуудын ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах, зөвлөгөө өгсөн.

"Эрүүл мэндийг дэмжигч" сургууль цэцэрлэгийг тодруулах үйл ажиллагааг 3 үе шаттай зохион байгуулж сургууль, цэцэрлэгүүдийг үйл ажиллагааг үнэлж, дүгнэхэд 91.2-97.7 хувийн үнэлгээтэй 10 сургууль, 91.4-98.5 хувийн үнэлгээтэй 13 цэцэрлэг үнэлэгдэж "Батламж" олгосон.

Монголын Усан спорт сонирхогчдын холбооны нэрэмжит 4 дэх удаагийн усанд сэлэлтийн тэмцээнийг 2017 оны 12-р сарын 15-наас 17-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Усан спорт сургалтын төвд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 10 багийн /Орчлон сургууль, Виста, Говьсүмбэр УССТ, Хангарьд, Хилэм, Сонгино хайрхан УССТ, Баянзүрх УССТ, Усан спорт сургалтын төв /-ийн 120 гаруй тамирчид 9-11, 12-14, 15-дээш насны гэсэн ангилалд мэлхий сэлэлт, өврөөр даллах сэлэлт, араар даллах сэлэлт, далайн гахай сэлэлт, холимог сэлэлт, холимог буухиа гэсэн сэлэлтийн төрлүүдээр хурд хүч авхаалж самбаагаа сорилоо.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2017 оны 11 дүгээр сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 830 байсан бол 205 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 42 ажлын байранд 34 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 139 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 862 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 12 сарын байдлаар 33242 иргэнд 9,893,367,002 төгрөгийг олгоод байна.

2018 онд сумдын Хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн мэдээллийг программд шууд шивж оруулах болсонтой холбогдуулан 12 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд сумдын хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж ажиллалаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөрлөг”-ийг 19 сумын хэмжээнд зохион байгуулж 1216 иргэн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, байнгын асаргаанд байгаа иргэдийг асран хамгаалж байгаа иргэдийг оролцууллаа. Өдөрлөгийн үеэр сумдуудад Нийгмийн даатгалын байцаагч, Эрүүл мэндийн төвийн их эмч, Иргэний бүртгэлийн байцаагч, Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн нар хамтран холбогдох хууль тогтоомжийн талаар зөвөлгөө, мэдээлэл өгч “АХА”, “Караоке”, гар бөмбөгийн тэмцээн зэрэг хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нэмэлт санхүүжилт тусгагдсантай холбогдуулан 13 сумын ЗДТГ, 2 тосгоны Захирагчийн албанаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ойн цэвэрлэгээ, зам давааны цас мөс арилгах ажилд орон нутгийн зорилтот өрхийн 458 иргэнийг түр ажлын байраар хангаж, 56458.0 мянган төгрөгийг зарцуулан ажиллалаа.

3. Эрүүл мэндийн талаар

“Эрүүл шүд” аяныг Хушаат, Жавхлант, Сант сум, Дулаанхаан, Түнхэл тосгонд зохион байгуулж байна.

Сүхбаатар, Шаамар сумын МСҮТ-ийн оюутнуудад “ДОХ, БЗДХ-ын эсрэг хамтдаа” сургалт, өдөрлөгийг зохион байгуулж 200 гаруй хүн хамрагдсан.

2017 оны 12 дугаар сард Хүдэр Сант, Баянгол сумдад Халдварт болон Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг 15-аас дээш насны иргэдэд зохион байгуулж 3198 иргэнийг хамруулж сумын хүн амын мэдээллийг цахим санг үүсгэн ажилласан.

Сэлэнгэ аймагт эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран зохион байгууллаа. Шалгалтанд Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгийн нийт 27 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж 15 хүн тэнцсэн байна.

4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах аяны хүрээнд Сүхбаатар, Түшиг сумдын ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтнууд, 15 байгууллагын 7892 хүнд хууль зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа. Мөн ерөнхий боловсролын сургуулиудад “Хөгжлийн мод” тарих арга хэмжээг зохион байгуулж 8000 орчим хүүхдийн санал санаачилгыг хүлээн авсан. Хүүхдийн хүчирхийллийг бууруулах зорилгоор “Нэгдүгээрт хүүхэд” уриалгад 10 байгууллагын 220 албан хаагчид нэгдсэн.

“Гэр бүлийн хүчирхийллийг тэг болгоё” сарын аяны хүрээнд 21 төрийн байгууллага, 17 сумын төрийн болон аж ахуйн нэгж бүрийг “Эцэг эхийн зөвлөл”-тэй болгох, шинээр батлагдсан хуулийг сурталчлах ажлыг зохион байгууллаа.

“Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-д 17 сумын төрийн албан хаагчид оролцон “Хүчирхийлэлд үгүй гэж хэлье” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж “Охин” богино хэмжээний кино үзүүлэн, 400 ширхэг гарын авлага түгээсэн.

Оны шилдэг хүүхдэд нийт 34 сургуулийн 70 гаруй хүүхдийн материал ирснээс тухайн ондоо өндөр амжилт гаргасан 10 хүүхдийг “Оны шилдэг хүүхэд”-ээр шалгаруулж батламжилсан. Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн Ч.Хүрэлсүхийн ивээл дор 2017 оны “Шилдэг сурагч”-аар Сүхбаатар сумын Улсын Тэргүүний 2 дугаар сургуулийн сурагч Г.Цэлмүүн шалгарсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах Олон Улсын өдрийн хүрээнд “Хүүхдийн төлөө хамтдаа” уриан дор 11 чиглэлээр арга хэмжээ зохион байгуулж 300 гаруй зорилтот бүлгийн хүүхдийг хамруулж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүллээ.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс нь 2017 оны 12 дугаар сарын байдлаар 26,73 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс өссөн дүнгээр 26,11 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 97.7 хувийн биелэлттэй ажилласан байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 15941 тэтгэвэр авагчдад 50401.13 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 6760 хүнд 2235.63 сая төгрөгийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, Жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжинд, нөхөн төлбөр, сувиллын зардалд 302 хүнд 1011.20 сая төгрөгийг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 538 хүнд 724.01 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 4469.39 сая төгрөгийн зардлыг тус тус олгожээ.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоос 2017 оны 12 дугаар сард 344 хүнээс 24 хүнийг цуцалж, 42 хүн шинээр тогтоон, 278 хүн актаа сунгуулсан.

Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс Сүхбаатар сумын “Урсгал ус” ХХК-ны 55 ажилчдад тэтгэвэр, тэтгэмжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн талаар сургалт зохион байгууллаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Сэлэнгэ аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс гурилын үйлдвэрүүдэд 71045 тн улаанбуудай тушаасан 233 аж ахуйн нэгж, иргэдийн урамшуулалын материалыг сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-нд хүргүүлж, урамшуулал авах эрхийг үүсгээд байна.

“Бизнес төрөлжүүлэлт” хөтөлбөрийн хоёр дахь удаагийн сургалт болох санхүүгийн тооцоо гаргах сургалтанд 15 иргэнийг хамруулж, чадавхижууллаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан Органик хүнс хөдөө аж ахуйн үндэсний II чуулган ба “Органик хүнсний баталгаажуулалт” сэдэвт сургалтанд 1 мэргэжилтэн, Сант сумын “Усан хээр” хоршооны дарга нийт 2 хүнийг оролцуулсан. Энэхүү сургалт чуулганаар органик салбарын бодлого, журам, стандарт, баталгаажуулах систем, стратеги, хөндлөнгийн баталгаажуулалтын талаарх ерөнхий зарчим, ойлголтууд, дотоодын хяналтын тогтолцооны талаар мэдлэг эзэмшиж, үйлдвэрлэгчдэд мэдээлэл түгээх арга зүйд суралцсан.

Аймгийн ХАА-н хоршоологчдын холбоо 7 дугаар бүгд хурлаа хийж холбооны тэргүүн, тэргүүлэгч, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, 2018 онд хийх ажлын төлөвлөгөөг ярилцлаа.

Аймгийн хаврын хэрэгцээт нөөцийн махыг бэлтгэх зорилгоор мах бэлтгэн нөөцөлж, борлуулах аж ахуйн нэгж, иргэдийг сонгон шалгаруулах, борлуулалтын явцад байнгын хяналт тавьж, санал дүгнэлт өгөх ажлын шинэчлэн батлуулсан.

“Мерси Кор” олон улсын байгууллагаас Сэлэнгэ аймгийн Хушаат сумын “Хушаатын баялаг” хоршоог түшиглэн “Казакын цагаан толгойт үүлдрийн үхрийн чанар, ашиг шим, бүтээгдэхүүний борлуулалтыг сайжруулах, үржлийн ажил үйлчилгээг чадавхижуулах нь” төслийг хэрэгжүүлж байна. Хоршооны бүх гишүүдийн хурлаар төслийн үр шим, цаашид хоршоогоо өргөжүүлэх, хамтран ажиллах талаар хэлэлцсэн бөгөөд төслийн зөвлөх багийнхан, гавьяат эдийн засагч Б.Авирмэд нар

хоршооны бүх гишүүдийн хурал, хоршооны дүрэм гишүүдийн оролцоог идэвхижүүлэх талаар сургалт зохион байгууллаа.

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх зорилгоор 100 тн өвс, 45 тн тэжээл, 16 сумын нөөцөд өвс, тэжээл бүрдүүлэх зорилгоор нийт 27 сая төгрөгийг сумдад шилжүүлж аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлээд байна.

Үхэр сүрэгт үзлэг ангилалт хийх тухай аймгийн Засаг даргын 2017 оны 05 сарын 11 өдрийн А/215 тоот захирамжийн дагуу Засаг даргын нөөц хөрөнгөөс 6.3 сая төгрөгийг гаргаж 10 сумын 6.8 мян.тол үхэрт үзлэг, ангилалт, ашиг шимийн гарцыг үүлдэр, нас хүйсээр тодорхойлох, цэвэр, эрлийз малын тоог тодорхойлох ажлыг зохион байгуулж ажиллаа. Мөн Мерси-Кор олон улсын байгууллагаас Хушаат суманд хэрэгжүүлж буй “Казакын цагаан толгойт үүлдрийн үхрийн чанар, ашиг шимийг сайжруулах, үржлийн ажлын чадавхжуулах” төслийн багаас тус сумын 49 өрхийн 2266 толгой КЦТ үхэрт ангилалт хийх ажлыг зохион байгууллаа. Ангилалтын дүнгээс үзэхэд ангилалтанд хамрагдсан нийт хээлтэгчийн 20.1 хувь нь дархан, 40.2 хувь нь торгон, 25 хувь нь 1-р анги, 15 хувь нь 2-р анги, хээлтүүлэгчийн 28 хувь нь дархан, 43.5 хувь нь торгон, 20 хувь нь 1-р анги, 8.5 хувь нь 2-р ангид тус тус хамрагдлаа.

Олон улсын худалдааны Хорио цээрт “А” зэрэглэлийн малын гоц халдварт шүлхий өвчний сэжиг Мандал сумын Минжийн хангайн 7-р багийн нутагт оршин суух Л.Даваагийн /95003611/ үхрээс авсан дээжинд хийсэн Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2017 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 15 цагт 17-2433 тоот шинжилгээний дүнгээр гоц халдварт шүлхий өвчний “О” хэвшил болох нь батлагдаж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн сумын Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 407 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоон халдварт өвчнийг түргэн шуурхай зогсоох ажлыг хийж байна. 12 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх байдлаар 155 айлаас дуудлага ирж 124 айлын өвчний шинж тэмдэг илэрсэн 1538 үхрийг устгалд оруулаад байна. 2017 оны 12 сарын 23-ны өдрийн байдлаар өвчний шинж тэмдэг илэрч устгасан малын тоо нэмэгдээгүй байна.

Голомтын бүсэд байгаа 400 мал бүхий өрхийн 3272 толгой үхэрт үзлэг тандалтыг ажилд 4 бүлэгт 8 малын эмч ажиллан 64 айл өрхийн 622 толгой малд үзлэг хийснээс 14 айл өрхийн 11 толгой үхэр сэжиг бүхий бүртгэгдсэн. Нийт үзлэг хийх өрхийн 34,2 хувь, үхрийн 48,8 хувьд үзлэг хийгээд байна. Мөн голомтын бүсэд байгаа мал бүхий өрхүүдэд 202 боодол өвс тараасан.

Эрүүл бүсийн хонь ямааг вакцинжуулах ажилд Орхироо, Тарни, Хэрх, Түнхэл, Бороогийн чиглэлд Баруунбүрэн, Сант, Хушаат, Жавхлант сумдын хөдөө аж ахуйн тасгийн малын эмч, Жавхлант сумаас мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч нийт 5 малын эмчийг татан оролцуулж, вакцинжуулалтанд хамруулбал зохих нийт 287 өрхийн 26483 ямаа, 28260 хонь нийт 54743 бог малаас 42 өрхийн 5130 толгой хонь, 4695 ямаа нийт 9825 толгой бог малыг буюу вакцинд хамрагдвал зохих өрхийн 14,6 хувь, вакцинжуулах малын 17,9 хувийг хамруулаад байна.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Хүдэр, Ерөө, Мандал сумдын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг бэлчээр, тариалан, аялал жуулчлал, хадгалан хамгаалах газарт хийсэн. Уг ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай 156.7 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох сумдын төсөвт

тусгах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Цаашид ажлын давхардал үүсгэхгүй байх зорилгоор газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг “Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний хүрээнд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг бүх сумдын хэмжээнд хийж дуусгах зорилт тавин ажиллаж байна.

2017 оны 12 дугаар сарын байдлаар хөдөө аж ахуйн газарт 19 зориулалтаар 292856 га, хот тосгоны газарт 18 зориулалтаар 1884,90 га газрыг иргэн аж ахуйн нэгж байгууллагад өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар авч нэгтгэсэн бөгөөд нийт 23 зориулалтаар 1991 нэгж талбарыг 1940 иргэн, 43 аж ахуйн нэгж, 6 төрийн байгууллагад өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулсан талаарх мэдээллийг гаргасан.

2017 оны жилийн эцсийн байдлаар газрын цахим биржийн барьцаа бүртгэлийн хэсэгт Сүхбаатар суманд 65, Баянгол суманд 1, Ерөө суманд 3, Жавхлант суманд 1, Зүүнбүрэн суманд 1, Мандал суманд 216, Орхонтуул суманд 3, Сайхан суманд 11, Түшиг суманд 4, Хүдэр суманд 1, Цагааннуур суманд 1, Шаамар суманд 9 буюу аймгийн хэмжээнд нийт 318 барьцаа бүртгэл бүртгэгдсэн байна. Зах зээлийн үнийн мэдээг Сүхбаатар суманд 8, Алтанбулаг суманд 2, Баянгол суманд 4, Мандал суманд 8 аймгийн хэмжээнд нийт 22 үнийн мэдээг цахим биржид бүртгэсэн байна. 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэхээр тусгагдсан газраас Сүхбаатар, Алтанбулаг, Баянгол сумд газрын цахим биржээр 9 газрын 65992 м² газрын дуудлага худалдааны зарыг байршуулсанаас Сүхбаатар суманд худалдаа үйлчилгээний зориулалттай 1 нэгж талбарын 92м² газрыг 1020,0 мянган төгрөгөөр, Алтанбулаг суманд худалдаа үйлчилгээний зориулалттай 1 нэгж талбарын 400м² газрыг 534000 мянган төгрөгөөр, Баянгол суманд танхимаар худалдаа үйлчилгээ, ШТС-ын зориулалттай 1 нэгж талбарын 10000 м² газрыг 8122,6 сая төгрөгөөр тус тус худалдаж эзэмшүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар түгээмэл тархацтай орд газрын 72 тусгай зөвшөөрөл, уул уурхайн ашигт малтмалын 193 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа талаарх судалгааг нэгтгэсэн. Ашигт малтмал, газрын тосны газрын онлайн кадастрын системээс мэдээлэл бүрдүүлэх ажлыг хийж эхэлсэн бөгөөд аймгийн хэмжээнд байгаа бүх тусгай зөвшөөрлийн кадастрын зургийг бэлтгэж дууссан. Цаашид эдгээр мэдээлэлд үндэслэн “Газрын тухай” хуулийн дагуу тусгай зөвшөөрөл бүхий газруудад эрхийн гэрчилгээ олгож, баталгаажуулах ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажил хангагдсан болно.

Долоо.Сум орон нутгийн талаар:

Баруунбүрэн сум:

Сумын ИТХ-ын хуралдаанаар 2017 онд байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэвшүүлсэн зорилт, аймаг сумын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан заалтуудын хэрэгжилт, 2018 онд сумын эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах зорилт зэрэг асуудлуудын хэлэлцүүлээ. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ойн санг гэрээгээр эзэмшигч иргэдийн нөхөрлөлүүдийн тухайн жилд хийсэн ажлын тайлан, ойн менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэлээ.

Сайхан сум дахь Сум дундын шүүхтэй хамтран зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр сумын иргэдэд шинэчилэгдэн батлагдсан хуулиудын

талаар мэдээлэл хийж, гарын авлага тараан сумын ЗДТГ-ын жилийн эцсийн тайланг танилцуулж ажиллалаа.

Орхоны бүсийн сум дундын ойн ангид аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас биотехникийн арга хэмжээний зардалд олгосон 1.000.000 төгрөгний санхүүжилтын хүрээнд бүсийн хэмжээнд сонгогдсон Ар бургалтай, Тэлт Хушаат, Ар тойлбо зэрэг агнуурын бүс нутгуудад 12 дугаар сарын 05-наас 10-ныг хүртэлх хугацаанд биотехникийн арга хэмжээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Баянгол сум:

Зорилтот бүлгийн болон амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой өрхөд туслах, тэдэнд сэтгэлийн дэм өгөх зорилго бүхий “Юу байна түүгээрээ” сайн үйлсийн аяныг төр, төсвийн байгууллагуудын дунд өрнүүлж эхэлсэн бөгөөд аянд сумын ЗДТГ, 21-р цэцэрлэг, Соёлын төв болон сумын Залуучуудын холбоо нэгдэн орсон.

Сумын Засаг даргын 2017 оны А/158 дугаар захирамжаар насанд хүрээгүй хүмүүст хэрэглээний хий худалдан борлуулахыг хориглон худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд шийдвэрийг хүргүүлэх, сумын Цагдаагийн тасаг, багийн Засаг дарга нар хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас хэрэгжүүлж буй “Номын өргөө” төслийн нээлтийн арга хэмжээг сумын Улсын тэргүүний ерөнхий боловсролын сургууль дээр зохион байгууллаа.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу ажил идэвхитэй хайгч 2 иргэнийг шинэ ажлын байранд, 3 иргэнийг сул байгаа ажлын байранд зуучилж ажлын байраар хангалаа. “Майнд тэч” ХХК-ийн шинээр ашиглалтанд оруулах дамжлагын үйлдвэрийн талаар компаний удирдлагуудтай уулзалт хийж, хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны талаар санал солилцон хамтран ажиллахаар харилцан тохиролцлоо.

Зүүнбүрэн сум:

“Авлига ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага хамт олон” аян зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2017 оны А/163 тоот захирамжаар байгуулан аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Би авлигагүй орчныг хүснэ” гар зургийн уралдааныг зохион байгуулж амжилттай оролцсон сурагчдыг өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагналаа.

“Гэр бүлийн хүчирхийлэлийг тэг болгоё” сарын аяны хүрээнд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ”, “Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан”, “Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” зэрэг сэдвүүдээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж 80 гаруй иргэд хамрагдлаа. Сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан гэр бүл, иргэдийг гарын авлага тараах материалаар ханган ажиллаа.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран нийтийг хамарсан “Ой цэвэрлэгээ” төслийг хэрэгжүүлж, 20 иргэнийг түр ажлын байраар ханган 2.8 сая төгрөгийн цалин олгосон бөгөөд амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой, байнгын асаргаанд байдаг 5 өндөр настанд түлшний мод олголоо.

Жавхлант сум:

Сумын Засаг даргын 2017 оны А/143 дугаар захирамжаар байгуулагдсан Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт, зөвлөн туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүн сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төвийн үйл ажиллагаатай танилцан үзлэг шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. Үзлэг шалгалтын үеэр гарсан алдаа дутагдал, илэрсэн зөрчлийн талаар зөвлөн тусалж зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын баг тус суманд ажиллан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, сумын эрүүл мэндийн мэдээллийн цахим санг бүрдүүлэх зорилго бүхий цогц үзлэг оношлогоог явууллаа. Үзлэг оношлогоонд 15-аас дээш насны 1371 иргэн хамрагдахаас 888 иргэн хамрагдлаа. Мөн дэвшилтэт технологийн зөөврийн дижитал рентген аппаратыг хүлээлгэн өгөх арга хэмжээнд аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, ЭМГ-ын дарга Ж.Од, Глобаль сангийн тэргүүн Н. Оюунбилэг нар оролцлоо.

Мандал сум:

Минжийн хангайн багт гарсан үхрийн шүлхий өвчний голомтын болон эрүүл бүсэд 2 удаагийн вакцинжуулалтанд 1385 өрхийн 30447 толгой мал амьтныг хамрууллаа. Мөн эрүүл бүсийн 202 өрхийн 54077 толгой бог малыг вакцинжууллаа.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 6 настай сургуульд суралцаж байгаа болон сургуульд хамрагдаагүй 6 настангуудын бүртгэл судалгааг гаргасан.

Суманд тогтоосон хорио цээртэй холбоотойгоор ерөнхий боловсролын сургуулиудын холоос хичээлдээ явж байгаа сурагчдыг том оврын автобусаар зөөх хуваарь гаргаж, хичээл тарах үед аюулгүй байдлыг хангах үүднээс жижүүр томилуулж ажилуулсан.

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг, Улаанбаатар төмөр замын Зүүнхараа өртөөний ажилчдын 40 айлын орон сууцны барилга баригдаж ашиглалтанд орлоо.

Сумын төвийн айл өрхүүдэд 8 хүртэл тарифтай, тоолуурыг алсаас таслах, залгах мөн хянах системтэй, олон улсын стандартад бүрэн нийцсэн ухаалаг тоолуурыг суурилуулах ажлыг эхлүүлж, Баянсуудлын 3-р баг, Баянхангайн 6-р баг, Баян-Арцатын 9-р багт нийт 569 ширхэг ухаалаг тоолуур суурилуулаад байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд 2017 оны 12 дугаар сарын байдлаар нийт 679 иргэнд 88,05 га газрыг өмчлүүлснээс хуучин амьдарч байгаа газраа өмчлөх 37 иргэнд 9 га, шинээр 642 иргэнд 79,05 га газар өмчлүүллээ. Хамтран өмчилсөн газраа гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх 13 иргэний 2,8га газрын өмчлөлийн асуудлыг шийдвэрлэлээ.

Сайхан сум:

“ХҮЛЭЭЖ БИШ ХҮРЧ ҮЙЛЧИЛБЭ” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгт Сум дундын цагдаагийн хэлтэс, Сум дундын эмнэлэг, Аврах, гал унтраах 61-р анги, сумын наториатч нар оролцон иргэдэд өөрийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр үйлчилсэн байна.

“ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛ” сэдэвт төрийн албан хаагчдын анхдугаар зөвлөгөөнийг 3 үе шаттайгаар зохион байгуулав. Сумын хэмжээнд нийт 19 төрийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээр байгууллагуудыг 8 багт хуваарилан ажиллуулж, “ХИШИГ ӨДӨР” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

Сумын хэмжээнд хэрэгжүүлэх 4 бүлэг 52 заалт бүхий хууль эрх зүйн ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан “ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛГҮЙ СУМ БОЛОХЫН ТӨЛӨӨ ХАМТДАА” уриан дор зохион байгуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Сайхан сумын Засаг даргын 2017 оны захирамжаар Монгол улсын Газрын тухай хуулийн дагуу өмчлөлийн зориулалтаар үнэ төлбөргүй 153 иргэнд, эзэмшлийн зориулалтаар 22 иргэнд тус тус газрын шийдвэр гарсан.

Сант сүм:

Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдийг тохиолдуулан сумын хэмжээнд нийгмийн дэг журмыг сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор сумын Засаг даргын 2017 оны А/75 дугаар захирамжаар хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллуулж амралтын өдрүүдэд гарсан зөрчилгүй хэвийн ажилласан байна.

2017 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын ажлыг зохион явуулах тухай сумын Засаг даргын 2017 оны А/66 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон ажиллалаа. Хяналтын тооллогод 21 өрхийн 9320 толгой мал хамрагдсан байна. Нийт дүнгээр тус суманд тэмээ 3, адуу 4556, үхэр 11347, хонь 40694, ямаа 26454, бүгд 83054 толгой мал тоологдсон байна.

Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, сумын эрүүл мэндийн мэдээллийн цахим санг бүрдүүлэх цогц үзлэг оношлогоо суманд 12 сарын 15-наас 17-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Үзлэгээр сумын 15-аас дээш насны 707 иргэний цахим мэдээллийг үүсгэн хамруулж 3 төрлийн 800 ширхэг гарын авлага тараасан. Дээрх үйл ажиллагаанд эрүүл мэндийн хөтөлбөрийн төсвөөс 2 сая төгрөг, сумын ЗДТГ-аас 1 сая төгрөг нийт 3 сая гаруй төгрөгийн санхүүжилт зарцуулагдсан байна.

Хушаат сүм:

Улс тунхагласны 93 жилийн ойг тохиолдуулан 16 нас хүрч Монгол улсын иргэн болсон сурагчдад иргэний үнэмлэхийг гардуулах, иргэний андгай өргөх ёслолын үйл ажиллагаа боллоо. Арга хэмжээний үеэр "Зөрчлийн тухай хууль-Хүүхдийн эрх" "Зөрчлийн тухай хууль- Иргэний бүртгэл" сургалтуудыг зохион байгуулсан.

"Эрүүл шүд-Сэлэнгийн ирээдүй" уриан дор 3-аас 16 насны хүүхдийн шүдний эмгэгийг оношлох, эмчлэх, зөв дадал зуршил олгох "Эрүүл шүд" сэдэвт аяны нээлт тус суманд болж "Эрүүл шүд" сургалтыг эцэг эхчүүдэд зориулан зохион байгууллаа. Аян Хушаат суманд 2017 оны 12-р сарын 22-ноос 25-ны өдрүүдэд явагдаж, суманд бүртгэлтэй 389 хүүхэд үзлэгт хамрагдсанаас өвчлөлтэй гарсан 210 хүүхэд эмчилгээ хийж, өвчлөлтэй гарсан хүүхдүүдийн 90 хувь нь хамрагдлаа.

“Мерси кор ” Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” төслийн хүрээнд төслийн зөвлөх багийн гишүүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын V хуралдаанд оролцож, төслийн танилцуулга, төсөл хэрэгжиж эхэлснээс хойш хийсэн хийсэн ажлын тайлан, төслийн хүрээнд хийгдсэн суурь судалгаанд үндэслэн боловсруулсан Хушаат сумын МАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний төслийг танилцууллаа.

Цагааннуур сүм:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэх ажлын хүрээнд иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, гарын авлага материалыг тараасан ба иргэдийн дунд чөлөөт ярилцлага өрнүүлэн санал бодлоо солилцлоо. Арга хэмжээний үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд хөгжөөн цэнгээнт “Аха” болон “1 минут

50000” тэмцээн зохион байгуулан тэмцээн тус бүрт 1-4 байр эзлүүлэн ивээн тэтгэгч байгууллага болох “Ноён Уулын хишиг” ХХК-ийн шагналыг гардууллаа.

Суманд ажиллаж буй мини маркет, хүнсний дэлгүүр, бар, кафе, цайны газрууд, хүнсний үйлдвэрлэлд ашиглаж байгаа түүхий эд, бүтээгдэхүүний чанар, худалдан борлуулагдаж байгаа хүнсний бараа, архи согтууруулах ундааны чанар, аюулгүй байдал, хаяг шошгололт, нийтийг хамарсан баяр ёслолын үеэр гарч байгаа өргөтгөсөн худалдаа, явуулын худалдаанд засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

“Зөв сонголт- зохистой хэрэглээ” сарын аяны хүрээнд сумын албан ёсны цахим хуудас болон “Цагааннуураар сонин юу байна”, “Нуурын мэдээ”, сумын facebook хуудсаар дамжуулан зөвлөмж, сэрэмжлүүлэг гарган иргэдэд сурталчилж ажиллав.

БОЛОВСРУУЛСАН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Н.ДҮҮРЭНБАЯР

ХЯНАСАН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Ө.СУВДАА